

1. Эцэг эхийн системийн тухай

Орчин үеийн боловсролын салбарын мэдээллийн системийг ашигласнаар эцэг эхчүүд хүүхэдтэйгээ илүү ойртож сурлагын мэдээллийг цаг алдалгүй авах боломж нээгдэж байгаа бөгөөд бидэнтэй хамтран боловсрол олгох үйл ажиллагаанд идэвхитэй оролцоорой.

Та эцэг эхийн системийн хэрэглэгч болсноороо дараах мэдээллүүдийг харах боломжтой.

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдагчдын эцэг эх:



Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын эцэг эх:



Та эцэг эхийн систем хэрэглэх боломжууд:

1. Интернет хөтөч ашиглан **PARENT.EDU.MN** сайт ашиглах
2. Гар утасны **ESIS** гэдэг аппликейшн татан авч ашиглах / android, ISO/



Доорх бар кодыг гар утсандаа уншуулан аппликейшн татан авах боломжтой.



ESIS.
PARENT. **EDU.MN**


2. Эцэг эхийн системд бүртгүүлэх заавар

Эцэг эхийн системд бүртгүүлэх


Эцэг эх системд бүртгүүлсэнээр өөрийн хүүхдийн хичээлийн хуваарь, дүн үнэлгээ, ирц, чөлөө авах, хичээлийн жилд судалж байгаа хичээлүүд зэрэг мэдээллүүдийг харах боломжтой.

Шинээр хэрэглэгч үүсгэхэд дараах алхамчилсан зааврын дагуу бүртгүүлнэ.

1. <https://parent.edu.mn/login> эцэг эхийн систем рүү нэвтрэн орно.



2. Эцэг эхийн системд шинээр бүртгэл үүсгэхэд баруун дээд хэсэгт байрлах **БҮРТГҮҮЛЭХ** гэсэн товч руу нэвтрэн орно.




3. Бүртгүүлэх цэсийг дарахад дараах цонх гарч ирэх бөгөөд талбарт өгөгдсөн утгуудыг бөглөж **ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ** товч дээр дарна.

а. **Имэйл хаяг:** Эцэг/эх өөрийн имэйл хаягаа оруулна. /Имэйл хаягаар баталгаажуулах код очих тул баталгаат имэйл хаягаа ашиглах/


б. **Утасны дугаар:** Өөрийн утасны дугаарыг бичнэ.

в. **Нууц үг:** Заавал том үсэг агуулсан байх, заавал тоо оруулсан байх, багадаа нэг тусгай тэмдэгт агуулсан байх, 8 тэмдэгт агуулсан байх шаардлагатай.



4. Бүртгүүлсэн и-мэйл хаяг эсвэл утасны дугаарт хэрэглэгчийн эрхийг баталгаажуулах код очно.

а. **Хэрэглэгчийн эрхийг баталгаажуулах код:** Тухайн кодыг хуулбарлан, хэрэглэгчийн бүртгэл баталгаажуулалтанд ашиглана.



< 138080



Add to contacts

Block number

Wednesday, 15 September 2021



parent.edu.mn - tani**i** batalgaajuulah kod:
[538387](https://parent.edu.mn)

8:58 am



5. **Үргэжлүүлэх товч** дарж шинэ хэрэглэгчийн бүртгэл талбарын дараах утгуудыг бөглөнө.

* **Регистрийн дугаар** /эцэг эх, асран хамгаалагч/

* **Овог нэр** /эцэг эх, асран хамгаалагч/

* **Баталгаажуулах код** /Утасны дугаар эсвэл имэйл хаягт ирсэн баталгаажуулах код/

Эцэг эхийн систем рүү хандаж өөрийн үүсгэсэн нэвтрэх нэр болон нууц үгээр нэвтрэн орно